

## МОНГОЛ УЛС БОЛОН БНХАУ-ЫН ӨВӨР МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Э.Наран,<sup>\*</sup>  
Ш.Амжилт<sup>\*\*</sup>

Сүүлийн жилүүдэд, Хятад Монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцаа гүнзгийрэн хөгжиж, хоёр орны эдийн засаг худалдааны харилцаа урьд өмнө байгаагүй хөгжиж, шинэ өндөрлөгт гарсан байна. Одоогоор, Хятад Улс нь Монгол Улсын худалдааны нэгдүгээр түнш болон хөрөнгө оруулагч улс болсон байна. Монгол Улс болон ӨМӨЗО-ы эдийн засаг худалдааны хамтын ажиллагаа бол хоёр орны эдийн засгийн харилцааны чухал хүчин зүйл болно.

### Нэг. Монгол, Хятадын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны шинэ байдал

1. 2007 онд, Хятад, Монголын хоёр талын худалдааны хэмжээ 2.087 тэрбум<sup>1</sup> ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 42.46% өсч, Монголын гадаад худалдааны нийт хэмжээний 50.66%-ийг эзэлсэн байна. Үүнд, Монголын Хятад руу экспортлосон хэмжээ 1.413 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 34.55% өсч, Монголын экспортын хэмжээний 74.1%-ийг эзлэв. Монголын Хятадаас импортлосон хэмжээ 674.3 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 62.48% өсч, Монголын импортын нийт хэмжээний 31.7%-ийг эзлэв.

1999 оноос хойш, Хятад улс 9 жил дараалан Монгол Улсын худалдааны нэгдүгээр том түнш болов. Хятад улс бол Монгол Улсын нэгдүгээр том экспортлогч, 2-дагч импортлогч орон болжээ.

2. 2007 оны эцэст, Хятадаас Монгол Улсад оруулсан хөрөнгө 1.181 тэрбум<sup>2</sup> ам.долларыг давж, хөрөнгө оруулсан төсөл 3769 байж, гадаад орнуудаас Монгол Улсад оруулсан хөрөнгийн хэмжээ болон хөрөнгө оруулсан төслийн 51.3%, 48.5%-ийг эзэлж байна. Монгол Улсад оруулсан хөрөнгийн хэмжээ болон хөрөнгө оруулж байгаа аж ахуйн нэгжийн тоогоор Хятад орон тэргүүлд, 1998 оноос хойш Хятад орон 10 жил дараалан Монгол Улсад хөрөнгө оруулагч нэгдүгээр том гүрний байр эзэлжээ.

<sup>\*</sup> Э.Наран - БНХАУ-ын ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургууль, доктор (Sc.D)

<sup>\*\*</sup> Ш.Амжилт - БНХАУ-ын ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

## **Хоёр. Монгол Улс болон ӨМӨЗО-ы эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа**

### **1. ӨМӨЗО-ы эдийн засгийн хөгжлийн тойм**

Өөрчлөлт нээлттэй бодлогыг дагалдан, Өвөр Монголын эдийн засаг тогтвортой, түргэн хөгжиж, эдийн засгийн чадавхи түргэн дээшилжээ. 2007 онд, Өвөр Монголын үйлдвэрлэлийн нийт өртөг 600 тэрбум юаниас давж, өнгөрсөн оныхоос 19%<sup>3</sup> өссөн байна. Энэ нь 2002 онд Хятадад 24-р байрт байснаасаа 2007 онд 16-р байр эзлэх болж, Хятадын дунд зэргийн хөгжилтэй муж, хот, ӨЗО-ы эгнээнд орсон байна. Өвөр Монголын сүү, ноолууран цамц, үхэр, хонины махны гарц болон чулуун нүүрс, цэвэр хужрын гарц, цахилгааны хэмжээ цөм Хятадад тэргүүлж байна. Хүн бүрт ногдох дундаж ДНБ ч бүх Хятадын эхний эгнээнд орсон байна. 2004 оноос эхэлж, хүн бүрт ногдох дундаж ДНБ 4 жил дараалан Хятадын эхний 10 байрыг эзлэх болжээ. 2007 онд, Өвөр Монголын хүн бүрт ногдох ДНБ 3300 ам.долларт хүрч, 3000 ам.доллараас 5000 ам.долларт хүрэх хөгжлийн ид үедээ орсон байна.

Өвөр Монголын эдийн засгийн түргэн хөгжлийг дагалдан, ӨМӨЗО-ы гадаад худалдаа өрнүүн хөгжиж байна. 2007 оны эцэст, Өвөр Монголд гадаад худалдааны үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж 3861 болон нэмэгдэж, дэлхийн 153 улс оронтой эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны харилцаа байгуулсан байна. Бүртгэснээр, 2007 оны нэг жилийн гаалийн экспорт импортын хэмжээ 7.745 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оныхоос 30.2% өсч, Хятадын баруун бүс нутгийн муж, ӨЗО, шууд харьяа хотуудын дотор 3-р байр эзэлсэн байна.

### **2. Монгол Улс, ӨМӨЗО-ы эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа**

#### 1. Хоёр талын худалдаа

1980-аад оны дундуур, Өвөр Монгол болон Монгол Улсын хооронд хил худалдаа хийж эхэлснээс хойш хоёр талын худалдаа Хятад, Монголын худалдааны нийт хэмжээний хагасаас дээш хувийг эзэлсээр иржээ. 2007 онд Өвөр Монголын Монгол Улстай хийсэн худалдаа 1.656 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 23.21% өсч, адил хугацаан дахь Хятад, Монгол хоёр талын худалдааны хэмжээний 80 орчим хувийг эзэлж байна. Үүнд, Хятадын Өвөр монголын импортын худалдааны хэмжээ 1.268 тэрбум ам.доллар, экспортын худалдааны хэмжээ 388 сая ам.долларт хүрсэн байна.

Өвөр Монгол болон Монгол Улсын худалдааны харилцан нөхвөрлөх чанар нэлээд давуу, импорт нь голдуу газрын тос, зэсийн баяжмал, нүүрс, малын ашиг шим зэрэг баялгийн чанартай

бүтээгдэхүүнээр голлож, экспорт нь тээврийн хэрэгсэл, барилгын материал, машин цахилгааны бүтээгдэхүүн, хувцас хунар гутал, жимс хүнсний ногоо зэргээр голлож байна.

**Импорт:** Монгол Улсаас импортолж байгаа газрын тосны хэмжээ жил дараалан нэмэгдэж байна. 2007 онд газрын тос импортолсон хэмжээ 106.1 мянган тн, барааны өртөг нь 56 сая ам.долларт хүрсэн өнгөрсөн оны мөн үеийнхээс тус тус 133.7% ба 166.7% өссөн байна. Үүний хамт, улсын дотоод болон олон улсын зах зээлийн газрын тосны эрэлтийн өсөлтийн улмаас, Монгол Улсаас импортлох газрын тосны хэмжээ болон барааны үнэ зэргээр өсч, 2007 оны 1-р сард 443 ам.доллар /тн байснаа мөн жилийн 12-р сард 664 ам.доллар/ тн болон өсч, өсөлтийн хэмжээ нь 49.9%-д хүрчээ. Угаасан ноолуурын импортын хэмжээ 1000 тн-ыг давж өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал 8.3% өссөн байна. Монгол Улс нүүрсний баялаг ихтэй, илчлэг сайн, хольц болон бохирдолт бага, 2007 оны эцэст нүүрсний импортын нийт хэмжээ 10 сая тн-д<sup>4</sup> хүрсэн байна.

**Экспорт:** 2007 онд, зөвхөн Эрээн хотын авто замын боомтоор 7931 ширхэг автомашин экспортолж, өртөг нь 109.42 мянган ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тус бүр 208%, 364% өсчээ. Цементийн импорт 304.7 мянга тн, өртөг нь 13.12 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал тус тус 82.4%, 124.6% өссөн байна. Жимс, хүнсний ногоо, өргөн хэрэглээний бараа жилийн дөрвөн улиралд тасралтгүй экспортолж байна.

## 2. Эдийн засгийн хамтын ажиллагаа

2007 оны эцэст Өвөр Монголоос Монгол Улсад 182 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж 27 аж ахуйн нэгж байгуулжээ. 2007 онд Өвөр Монголоос гадаадад 22 аж ахуйн нэгж байгуулж, Хятадын талын хэлэлцээрээр тохиролцсон хөрөнгийн хэмжээ 71.842 сая ам.долларт хүрчээ. Үүнд, Монгол Улсад хөрөнгө оруулсан 6 аж ахуйн нэгжийн Хятадын талын хэлэлцээрээр тохиролцсон хөрөнгө оруулалтын хэмжээ 33.188 сая ам.доллар болно. Гадаадад хөрөнгө оруулж байгаа төсөлд голдуу ашигт малтмал хайж олборлох, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт болон олон улсын худалдаа зэрэг болно.

2007 оны эцэст, Монголтой тендер хөдөлмөр хүчний гэрээний хэмжээ 549 сая ам.долларт хүрч, худалдаа үйлчилгээний хэмжээ 102 сая ам.долларт хүрч, гадаадад томилсон хөдөлмөр хүч давхардсан тоогоор 10080 хүнд хүрэв. 2007 онд Монголтой байгуулсан тендерын барилга хөдөлмөр хүчний хамтын ажиллагаа болон зураг төлөвлөгөө, зөвлөлтөгөө өгөх гэрээний хэмжээ 11.2 сая ам.доллар, худалдааны үйлчилгээний хэмжээ 4.61 сая ам.долларт хүрч, гадаадад томилсон

хөдөлмөр хүч давхардсан тоогоор 5.8 сая хүнд хүрчээ. Хоёр талын хамтын ажиллагааны хүрээ нь барилга, хүнсний ногоо тарих зэрэг энгийн хөдөлмөр хүчний хамтын ажиллагаагаас эхэлж, цахилгаан эрчим хүч, дулааны эрчим хүч, барилга засвар, ашигт малтмал олборлох, металлурги, тариалан, ноос ноолуур, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах зэрэг өргөн хүрээг хамарсан олон талт бүтэц бий болжээ.

### 3. Өвөр Монголын Монголд хэрэгжүүлж байгаа гол төслүүд

Сүүлийн жилүүдэд Монгол Улстай хамтран нүүрс, эрчим хүч болон ашигт малтмалыг хамтран нээж ашиглах талаар голлон ажиллаж байна.

1. Нарийн сухайтын нүүрсний уурхай. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дахь Нарийн сухайтын нүүрсний уурхай нь Өвөр Монголын Цэгээ боомтоос 48 км зайтай. Энэ уурхай бол ил, сайн чанарын утаагүй нүүрс гардаг, илчлэг нь 7000 ккал. 2002 оны 8-р сард, Өвөр Монголын Чинхуа групп, “Монгол алт” компани 30 жилийн хугацаат хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. 2004 оны 4-р сард Алшаа аймгийн Эзнээ хошууны Цэгээ боомтоор анх удаа чулуун нүүрс импортолж, 2008 оны эхний хагас болоход нийт 7.3 сая тн чулуун нүүрс импортолж, жилд дунджаар сая гаруй тн нүүрс импортлосон байна. Уурхайн бүсийн тээвэрлэх ба үйлдвэрлэл амьдралын нөхцлийг сайжруулахын тулд Чинхуа—МАК Нарийн сухайтын ХХК нь 100 шахам сая юаний хөрөнгө оруулж, Цэгээ боомтоос Нарийн сухайтын нүүрсний уурхай хүрэх 80 км нүүрсний тусгай зам, 56 км хар зам, Цэгээ боомтоос уурхайн бүс хүрэх 35 кв-ын өндөр хүчдэлийн цахилгаан шугам тавьж, мөн Гурвантэс сумд 6.3 кв-ын цахилгаан дамжуулах шугам тавьж, Хүүхэд залуучуудын цэнгэлдэх төв зэрэг барилга барив. Импортлогч улсын боомт дотоодын нүүрс хэрэглэгчдээс алс зайтай байгаа асуудлыг шийдвэрлэхийн төлөө, уг компани 500 сая юаний хөрөнгө оруулж Цэгээ боомтоос Алшаа аймгийн Устайн эдийн засгийн нээлттэй бүсэд 600 гаруй км нүүрс тээвэрлэх тусгай авто зам тавьжээ. Баруун хэсэгт Жючюаний ган төмрийн групп 1.9 тэрбум юаний хөрөнгө оруулж 170 км “Жяюйгуань боомт - Цэгээ” чиглэлийн төмөр зам тавив. Зүүн хэсэгт 5.3 тэрбум юаний хөрөнгө оруулж Линьхэ-Цэгээ хэсгийн 750 км төмөр зам энэ жилд ашиглалтад орох болно. Одоогоор Чинхуа групп Нарийн сухайтын сайн чанарын нүүрс, бусад ашигт малтмалыг ашиглаж байгаад Устайд нүүрс, кокс, хими, металлургийн аж үйлдвэрийн орчин үеийн нүүрс химийн бааз байгуулахаар төлөвлөж байна. Нарийн сухайтын нүүрсний уурхай нь уг аж ахуйн нэгжийн түүхий эдийн үйлдвэрлэлтийн гол бааз болж байна.

2. Баянцогтын нүүрсний уурхай. Энэ уурхай Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт, Шилийн гол аймгийн Зүүн хатавч

боомтоос 70 км зайтай, хүрэн нүүрсний ил уурхай, 120 сая тн нөөцтэй, илчлэг нь 6300 ккал. Энэ уурхайг Зүүн Үзэмчин хошууны “Мөнхийн гал” ХХК Монголын талтай хамтран нээж, Монгол Улсын Баянцогтын нүүрсний уурхайн ашигт малтмалыг олборлох лиценз авсан байна. Энэ төсөлд 73.78 сая юаний хөрөнгө оруулж, жилд 1 сая тн нүүрс олборлохоор төлөвлөж байна. Одоогоор 44 мянган тн нүүрс олборлон импортолж, 2008 онд 500 мянган тн нүүрс гаран авч, 25 сая юаний ашиг олохоор төлөвлөж байна.

3. Хар тугалга, цайрын орд. Дорнод аймгийн Чойбалсан хотоос 130 км, Хятад, Монголын Архашаат боомтоос 180 км зайтай, Улааны хар тугалга, цайрын орд, Мохорын хар тугалга, цайрын орд, Бутаны хар тугалга, цайрын ордны нийт нөөц 3.2 сая тн, зэсийн хүдрийн нөөц 68 мянган тн, мөнгөний хүдрийн нөөц 8449 тн, алсны нөөц 19630 тонн байна. Одоогоор, шинэ Барга баруун хошууны Шиньшинь ашигт малтмалын ХХК нь Улаанбаатарт “Улаанбаатарын Шиньшинь ХХК” байгуулж, Монгол Улсын хэдэн компанитай хамтран Улааны хар тугалга, цайрын ордыг нээх гэрээ байгуулав. Төслийн нийт хөрөнгө оруулалт 38 сая юань, үйлдвэрлэх хүчин чадал нь жилд 100 мянган тн олборлож баяжуулах болно. Одоо тоног төхөөрөмжөө угсарч туршин ажиллуулж, хилийн гадна оруулсан эхний хугацааны хөрөнгө нь 3.07 сая ам.долларт хүрчээ.

4. Цементийн үйлдвэрийн төсөл. Өвөр Монголын Жя-Ао хуванцрын ХХК Улаанбаатарт 600 мянган тн цементийн үйлдвэр байгуулж, 340 сая юаний хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа бөгөөд одоо эхний ээлжийн судалгааны ажил хийж байна.

#### 4. Өвөр Монгол үр ашигтай арга хэмжээ авч байна.

1. Хөнгөлөлттэй бодлого. 2007 оноос хойш, Өвөр Монгол олон талын дэмжих бодлого боловсруулж, аж ахуйн нэгжүүдийг Монгол, ОХУ-тай эдийн засаг худалдааны хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг чармайж байна. 2007 оноос эхэлж, хилийн чанадад боловсруулах, худалдаа, ашигт малтмал олборлох, мод огтлох зэрэг салбарт хөрөнгө оруулах хамтын ажиллагааны төсөл хэрэгжүүлэх өргөдөл гаргасан аж ахуйн нэгжид дам хүүтэй зээл олгож, төслийн эхний үеийн мөнгийг дэмжиж, Монгол, ОХУ хоёр орны эрчим хүч, ашигт малтмалын баялгийн хүрээнд хамтран ажиллахыг дэмжсэн байна. Үүний хамт, Өвөр Монгол нь Эрээн хот, Манжуур хотын аж ахуйн нэгжүүдийн Замын-Үүд болон ОХУ-ын Өвөр Байгалийн эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны бүс байгуулах ажлыг идэвхтэй дэмжсэн байна. Үүний дараа, Өвөр Монгол бас төсөл даан авч удирдах, ВОТ (барилга барих-худалдаа үйлчилгээ-шилжүүлэх), ЕРС (зураг төлөвлөгөө-бэлтгэх-бүтээн байгуулах) зэрэг хэлбэрээр Монгол Улс, ОХУ-ын төслийг хүлээн

авч, Монгол, Оросын олон улсын барилгыг даан авах ажлын хэмжээг өргөтгөх ажлыг дэмжиж байна.

2. Боомтын бүтээн байгуулалтыг түргэтгэв. Одоогоор Өвөр Монгол, Монгол Улсын хооронд 11 боомт байна. Хоёр талын эдийн засаг худалдааны хүрээг өргөтгөхийн тулд Хятад, Монголын хил дээр 8 боомт нэмж ажиллуулж, 2010 онд Эрээн хотоор төв болгосон нээлтэй бүтэц бий болгохоор Өвөр Монгол төлөвлөж байна. Сүүлийн жилүүдэд, Өвөр Монгол боомтын дэд бүтцийг бий болгох ажлыг эрчимжүүлж байна Эрээн болон Цээгээ боомт бол Өвөр Монголын хоёр том боомт болжээ.

2007 онд ӨМӨЗО-ны боомтоор орж гарсан бараа тээврийн хэмжээ 33.2 сая тоннд хүрч, 9.8% өсөв. Үүнд: Монголтой хиллэдэг боомтоор орж гарсан бараа 9.12 сая тонн буюу 6.4% өсөв. Хилээр орж гарсан зорчигчдын хэмжээ давхардсан тоогоор 3.76 саяар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 27% өссөн байна. Хилээр орж гарсан машин тэрэгний хэмжээ 750 мянгад хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 35% өсөв. 2007 оны эцэст, Эрээн хотоор дамжин Монгол Улсад очиж ажил хийсэн иргэдийн тоо давхардсан тоогоор 100 шахам мянгад хүрч, Хятадад ирж бараа худалдан авсан, суралцсан, эмчлүүлсэн хүн давхардсан тоогоор 500 гаруй мянгад хүрсэн байна.

### **Гурав. Хоёр талын эдийн засаг худалдааны харилцааг эрчимжүүлэх хэрэгтэй**

Эдүгээ Хятад, Монгол хоёр орны эдийн засаг худалдааны харилцаа түүхийн хамгийн сайн цаг үед оршиж байна. Хятад, Монгол хоёр орон, Өвөр Монгол болон Монгол Улсын эдийн засаг худалдааны харилцааг гүнзгийрүүлэн ахиулахад хоёр талын ашигтай хүчин зүйл болон сөрөг хүчин зүйлийг задлан шинжилж, түүнд зөвөөр хандсаны үндсэн дээр цаашдын хөгжлийн хандлагаа тогтоож, хоёр талаараа хөгжих зорилгод хүрвэл зохино.

#### **1. Ашигтай хүчин зүйлүүд**

Газар орны давуу тал. Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондох 3210 км урт хилийн шугам нь Хятад, Монголын хилийн шугамын 68.7%-ийг эзэлдэг. Өвөр Монголын 6 аймаг, хотын 15 хошуу, хот Монгол Улсын 6 аймгийн 26 сумтай хиллэдэг. Хоёр орны одоогоор ажиллаж байгаа 17 боомтын 11 нь Өвөр Монголд байдаг. Ийм газар орны давуу тал хоёр орны эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлж байна.

Харилцан нөхвөрлөх давуу тал. Хятад, Монгол хоёр орон, Өвөр Монгол хийгээд Монгол Улсын хоорондох ерөнхийлсөн хүчин чадлын асар их зэрөө ба эдийн засгийн бүтцийн адил бусаас болж, хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагааг харилцан нөхвөрлөх бололцоо олгож байна.

Нэгдүгээрт. Монгол Улс, дэлхийн үр тарианы үнэ өссөөр байгаа ба 50%-иас дээш хүнсний бүтээгдэхүүнээ экспортолж байгаа байдалд 2008 онд “Атарын 3-р аян” зохион байгуулж, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, үр тариагаар өөрийгөө хангахыг зорьж байна. Одоо энэ аяны хэрэгжилт нь газар тариалангийн машин механизм, технологийн хөрөнгө мөнгө болон ажиллах хүч дутагдах бэрхшээлтэй тулгарч байна. Тэгэхэд Хятадын талын уламжлалт газар тариалангийн технологи, газар тариалангийн дадамгай хөдөлмөр хүч болон газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах дэвшилтэт технологийг Монголд нэвтрүүлэх шаардлага байгаа.

Хоёрдугаарт. Монгол Улсын элбэг баялаг зэс, нүүрс, төмөр, газрын тос зэрэг нь Хятадын талын дутагдаж байгаа ашигт малтмалын баялаг ба одоогийн хэрэгжүүлж байгаа гадаадын хөрөнгийг татан оруулах, байгалийн баялгаа нээн ашиглах хөнгөлөлттэй бодлого болон Хятад, Өвөр Монголын түргэн хөгжиж байгаа эдийн засаг их хэмжээний эрчим хүч, түүхий эд шаардаж байгаатай харилцан нөхвөрлөх бөгөөд Хятадын талын харьцангуй дэвшилтэт технологи, туршлага, тоног төхөөрөмж хийгээд арвин их баялаг нь Монгол Улс баялгаа нээхэд дутагдаж байгаа зүйл болно.

Гуравдугаарт. Монгол Улсын уламжлалт малын ашиг шим, нээн хөгжүүлээгүй зэрлэг амьтан ургамлын баялаг нь Хятадын арьс ноос боловсруулах дэвшилтэт технологи, хятад монгол эм эмнэлэг, анагаах ухааны технологи болон асар том зах зээл зэрэгтэй харилцан нөхвөрлөх болно.

## **2. Ашиггүй хүчин зүйлүүд**

Монгол Улсын тал: 1. Эрчим хүч, ашигт малтмалыг нээн хөгжүүлэх талаар Монгол Улсын төрийн бодлогын тогтворгүй байдал, тогтоогдоогүй эрсдлийн хүчин зүйл бол Хятадын талын аж ахуйн нэгжийг Монголд очиж хөрөнгө оруулалт хийхийг хязгаарлаж байгаа чухал шалтгааны нэг болж байна. 2. Монгол Улсын байгаль орчин хэврэг, дэд бүтэц харьцангуй хоцронгуй, олон газарт ус, цахилгаан, замын систем бүрдээгүй болохоор эхний ээлжийн их хэмжээний иж бүрдсэн хөрөнгө оруулалт шаардаж, их бэрхшээл болон эрсдэлтэй тулгараад байна.

Өвөр Монголын тал: 1. Хятадын талын аж ахуйн нэгжүүдийн замбараагүй өрсөлдөөн нь хоёр талын хамтын ажиллагаа болон эдийн засаг худалдааны харилцааны хөгжилд сөргөөр нөлөөлж байна. 2. Аж

ахуйн нэгжүүдэд удирдах чадвартан дутагдаж байна. Гол илрэл нь: зонхилох аж ахуйн нэгж Монгол Улсын зах зээл, хууль тогтоомж, төрийн бодлогын тухай ойлголт бага, судалгаа дутмаг, мэдээлэл хаалттай байна. Хөрөнгийн төслийн эхний хугацааны судалгааг гүйцэд хийгээгүй, эрсдлийг дулуу жишсэн. Гадаадын хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх болон аж ахуйн эрхлэлт удирдлагын туршлага дутмаг зэрэг болно.

### **3. Цаашдын анхаарах чиглэл**

1. Хоёр талын засгийн газрын эрх бүхий байгууллагын үйл ажиллагааг дээшлүүлнэ. Монголын талд авч хэлбэл, Засгийн газар тэргүүлэх үүрэг гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомжоо бүрэн төгс болгож, хууль зүйн тогтворт чанар, залгамжит чанарыг батлах хэрэгтэй. Хятадын талд авч хэлбэл, Засгийн газар зохицуулах механизм байгуулж, хүчин чадалтай төрийн өмчит томоохон аж ахуйн нэгжүүд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг удирдан Монголд хөрөнгө оруулж, чанар болон итгэлийг нь баталж, манай талын аж ахуйн нэгжүүд хоорондоо өрсөлдөхөөс зайлсхийх хэрэгтэй.

2. Чадвартан бэлтгэх ажлыг хүндэтгэж, аж ахуйн нэгжүүдэд олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын менежмент бэлтгэн өгч, аж ахуйн нэгжүүдийн удирдлагын төвшин, эрсдлээс сэргийлэх чадварыг дээшлүүлнэ. Үүний хамт, гадагш томилох хөдөлмөр хүчнийг бэлтгэх ажлыг төгөлдөржүүлж, тэдний технологийн төвшин, хэлний чадвар, ерөнхий чансааг дээшлүүлнэ.

3. “Гадагш гарах” хэлбэрийг шинэчлэж, дан ганц шууд эрчим хүчний баялаг олж байсан хэлбэрийг өөрчлөх хэрэгтэй. Хамтын ажиллагааны чиглэлийн талаар хоёр талаараа ашиг олох ба харилцан ашигтай байхыг хүндэтгэж, эзэн улсын эдийн засгийн хөгжил болон аж үйлдвэрийн өсөлтийг ахиулж, эзэн улсын бие дааж хөгжих чадварыг эрчимжүүлнэ. Хамтран ажиллах хэлбэрийн талаар уян хатан байж, эрчим хүчний баялгаар цөм болгож, олборлох болон гүн боловсруулахыг уялдуулах, хөрөнгө оруулалт болон худалдааг уялдуулах, төсөл дааж авах болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг харилцан уялдуулах зэрэг олон төрлийн хамтын ажиллагааны хэлбэрийг ашиглана.

4. Өвөр Монгол болон Монгол Улсын хүмүүнлэг, газар зүйн давуу талыг гүйцэд ашиглаж, Монгол Улстай хийж байгаа Өвөр Монголын эдийн засаг худалдааг улам ахиулж, Хятад, Монголын харилцаа болон эдийн засаг худалдааны хамтын ажиллагаанд үзүүлэх Өвөр Монголын гүүр холбоосын үүргийг дээшлүүлэх хэрэгтэй.

5. Дэлхийд хосгүй тал нутагт буй Монгол Улсыг даяаршлын үүднээс харахад, тэндэх тал нутаг бол мөн ч дэлхийнх, иймээс газрын бөмбөрцгийн иргэн нэг бүр түүнийг хамгаалах үүрэгтэй. Уул уурхай



олборлох нь байгаль орчин экологид маш их нөлөөлдөг, иймээс Монгол Улсад уурхай нээхдээ байгаль орчныг хамгаалах асуудлыг тэргүүн байранд тавьж, уурхайн бүсийн байгаль экологийг сэргээх ажлыг хийж, тухайн газрын иргэдийн эрх ашгийг хамгаалах хэрэгтэй. Хоёр талын хамтын ажиллагаагаар Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжлийг ахиулж, Монгол Улсын иргэдэд жинхэнэ ашиг тус хүргэх хэрэгтэй.

### **ЭШЛЭЛ, ЗҮҮЛГ**

1. Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо: “Монгол Улсын статистикийн эмхтгэл 2007”, Улаанбаатар, 2008 он.
2. <http://www.fmprc.gov.cn/chn/wjb/zzig/yzs/gilb/1261/1261x0/befault.htm> материалаас тооцож боловсруулав.
3. ӨМӨЗО-ны Статистикийн Газар, Үндэсний Статистикийн Газрын Өвөр монголыг судлах баг: “ӨМӨЗО-ны 2007 оны улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн статистикийн мэдээ”, 2008 оны 2-р сарын 26-ны өдөр
4. Жэнь Хүйбинь: “Өвөр Монголын Монгол Улсаас импортолж байгаа нүүрсний нийт хэмжээ 10 сая тонн болов”, “Умардын шинэ сонин” 2008 оны 3-р сарын 31-ны өдөр